

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2025 оны 03 дугаар сарын 20-ний өдөр

ТУЗТ 01/2025

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн хувьцаа
эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах
тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дүгээр хэсэг, 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.6 дэх хэсгүүд, 71 дүгээр зүйлийн 71.3, 71.4 дэх хэсгүүд, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дэх хэсгүүд, “Эрдэнэс сольюшинс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дэх хэсгүүд, 9 дүгээр зүйлийн 9.10.10, 9.10.11 дэх хэсгүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталж 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 12.00 цагт Google Meet joining info Video call link: <https://meet.google.com/deq-wpio-bju> програмыг ашиглан, иргэний үнэмлэх, итгэмжлэлийг өөрийн зурагтай зэрэг камерт тулган баталгаажуулах байдлаар зарлан хуралдуулсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах этгээдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т. Золбоог томилсугай.
4. Энэ тогтоолын 2-т заасан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг 1 дүгээр хавсралтаар, хурлын хөтөлбөр, дэгийг 2 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын танилцаж болох баримт материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын загварыг 4 дүгээр хавсралтаар, тооллогын комиссын тогтоолын төслүүдийг 5, 6-р хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлийг 7-р хавсралтаар тус тус баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлэх өдрийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар, мэдээг 2025 оны 03 дугаар сарын 25-ний өдрөөр дахин зарлах өдрийг 15 өдрийн дараа байхаар тогтоож, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсны дагуу “Хувьцаат

компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журамд заасан хэлбэр, шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /М.Батцогт /-д даалгасугай.

7. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 17.00 цаг хүртэл ажлын өдрүүдэд ажлын 9-17 цагийн хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө 31, 2-р давхарт “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн байранд танилцуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс / М.Батцогт/-д даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокерын компаниар дамжуулан авч байгаа тохиолдолд уг саналын хуудсыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 16 цагаас өмнө байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулах комиссыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
10. Хурал зохион байгуулах комиссын даргаар М.Батцогт, гишүүнээр Г. Төгөлдөр нарыг, Тооллогын комиссын даргаар Г. Төгөлдөр, гишүүнээр: М.Батцогт нарыг тус тус томилсугай.
11. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн материалыг 2025 оны 04-р сарын 29-ны өдрийн 15 цагаар тасалбар болгон хүлээн авсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Г.ЗОЛБОО/